

**“Шатахууны жижиглэнгийн худалдааны үнийг
тогтворжуулах (SIFS) дэд хөтөлбөр”-ийн зээлийн
шугамын **6 дахь ашиглалт гарлаа****

Монголбанкнаас жижиглэнгийн нефтийн бүтээгдэхүүнийг хамгийн бага зардлаар санхүүжүүлэхийн зэрэгцээ хил дээрх өртгийн ханшаас хамаарах нөлөөллийг бууруулж, жижиглэнгийн борлуулалтын үнийг тогтвортой байлгах нөхцлийг бүрдүүлэх зорилгоор SIFS дэд хөтөлбөрийг Уул уурхайн яамтай хамтран 2012.10.26-ны өдрөөс хэрэгжүүлж байгаа билээ.

Энэхүү дэд хөтөлбөрийн 6 дахь транчаар хөтөлбөрт оролцогч банкаар дамжуулан **“Магнай трейд” ХХК**-д жилийн 3.8%-ийн хүүтэй, 1 жилийн хугацаатай **13.9** тэрбум төгрөгийн санхүүжилтийг өнөөдөр шилжүүллээ.

Түүнчлэн дэд хөтөлбөрт заасны дагуу Монголбанк нь оролцогч банкаар дамжуулан **“Магнай трейд” ХХК**-д нийт 13.9 тэрбум төгрөгтэй тэнцэх ам.долларыг **2** сарын дараа худалдах форвард хэлцлийг хамгийн бага зардлаар гүйцэтгэж, ханшийн эрсдлийг нь буурууллаа.

Ийнхүү зээлийн шугамын болон санхүүгийн үүсмэл хэрэгслийн гэрээгээ оролцогч банкуудтай байгуулсан хэрэгжүүлэгч **5 компани нь нийтдээ 76.7** тэрбум төгрөгийн зээлийн шугамыг ашиглаад байна.

Дэд хөтөлбөрийн өмнөх ашиглалт болон хөтөлбөрийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг Монголбанкны цахим хуудасны **“Үнийг тогтворжуулах хөтөлбөр”** цэснээс үзнэ үү. <http://www.mongolbank.mn/pricestability.aspx>